





Хавсралтууд

- 1. Багшид лавлагаа өгөх төмөр замын аюулгүй байдлын нэр томъёоны тайлбар толь**
- 2. Сургуулийн сурагчдад зориулсан сургууль руу явах аюулгүй маршрут хөтөлбөрийн ашиг тус**
- 3. Сурагчийн дасгал ажил**
- 4. Эцэг эхчүүдэд зориулсан аюулгүй байдлын мэдээлэл**
- 5. 2009-2019 оны замын хөдөлгөөний аюулгүй байдлын статистик мэдээ**
- 6. Монгол улсад 2009 он ба 2019 онд бүртгэгдсэн тээврийн хэрэгслүүд**

<p>Гэрлэн дохио</p>	<p>Галт тэрэгний машинист хэзээ зогсох, явахыг анхааруулдаг гэрлэн дохио (авто замын гэрлэн дохиотой ижил).</p>	
<p>Тавцан</p>	<p>Галт тэрэг ирэхийг хүлээдэг зорчигчдын зогсдог газар. Битүү эсвэл нээлттэй байж болно. Усны урсцыг хангах үүднээс төмөр зам руу бага зэрэг налуу хийсэн байдаг.</p>	
<p>Төмөр замын сүлжээ</p>	<p>Төмөр замын сүлжээ гэдэг нь тухайн улс, бус нутгийн доторх төмөр замын маршрут, төмөр замын дэд бүтцийг тодорхойлоход хэрэглэгддэг нэр томъёо юм. Үүнд бүх галт тэрэг, вагон, дохио, тэмдэг, зам, зорчигчийн тавцан, гарам, зүтгүүр гэх мэт орно.</p>	
<p>Төмөр замын дэр мод</p>	<p>Зам төмөртэй перпендикуляр тавьсан тэгш өнцөгт бетон эсвэл модон тулгуур. Галт тэрэгний жинг тархаах, зам төмрийг параллель байхад тусалдаг.</p>	
<p>Галт тэрэг</p>	<p>Галт тэрэг нь зүтгүүр дэх жолоочийн кабин, вагон тэргэнцрээс бүрдэнэ. Бараа, нүүрс болон бусад ашигт малтмал зэрэг ачаа, зорчигч тээвэрлэхэд ашиглаж болно. Галт тэрэг дизель түлшээр ажилладаг. Тэд төмөр замаар явдаг дугуйтай. Галт тэрэг зөвхөн урагшаа явдаг(ухрах хөдөлгөөнгүй), эсрэг чиглэлд явах үед жолооч төгсгөлийг нь шилжүүлдэг. Зорчигч тээврийн галт тэрэг, ачааны галт тэрэг, нүүрсний галт тэрэг, дизель галт тэрэг гэж бий.</p>	

Шар шугам	<p>Тавцан дээр будсан шар шугам нь тавцангийн аюулгүй хэсэг дуусаж байгааг хүмүүст сэрэмжлүүлэх зорилгоор хийсэн болно. Тэдний зорилго бол хүмүүсийг галт тэргэнд дайруулах, тавцан дээрээс унахаас хамгаалах явдал юм.</p> <p>Олон оронд шар шугамын оронд өнгийн товруутай хавтанг ашигладаг бөгөөд, илүү их хамгаалалттай, хараа муутай хүмүүсийн аюулгүй байдлыг хангахад тусалдаг.</p>	
-----------	---	--

СУРГУУЛЬ РУУ ЯВАХ АЮУЛГҮЙ МАРШРУТ ХӨТӨЛБӨРИЙН ҮР АШИГ¹¹

АЮУЛГҮЙ МАРШРУТЫН ТҮНШЛЭЛ

СУРГУУЛЬ РУУ ЯВАХ АЮУЛГҮЙ МАРШРУТЫН АШИГ ТУС

Сургууль руу явах аюулгүй маршрут нь явган хүний зам, гудамжны гарцыг сайжруулж, хүүхдүүдэд дугуй унах, сургууль руугаа ирж, буцах аюулгүй, тохь тухтай, хөгжилтэй боломжийг бүрдүүлдэг. Сургууль руу чиглэсэн аюулгүй замыг таван жилийн хугацаанд зардал багатай, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг харуулсан цөөн хөтөлбөрүүдийн нэг гэж хүлээн зөвшөөрсөн.

ЗАРДЛЫН ХЭМНЭЛТ

- Хийн түлш, автомашины хэрэглээг багасгаснаар өрхийн хэмнэлт
- Сурагчийн автобусны зардлыг бууруулах замаар боловсролын төсвийн хэмнэлт

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Сургуулиудын ойролцоох гудамж замын тохижилтыг хийснээр сурагч, олон нийт ирж, буцах үед гарах замын хөдөлгөөний аюултай байдал ба зам тээврийн ослын гэмтлийг бууруулсан
- Сурагчид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сурч, дадлагажих илүү их боломж

ЦАГ УУРЫН АШИГ ТУС БА ЦЭВЭР АГААР

¹¹ Эх сурвалж: Аюулгүй маршрутын түншлэл, АНУ-ын Форт Вашингтон <https://www.saferoutespartnership.org/>

- Автомашины жолоодлого бага, агаарын бохирдол үр дүнд нь буурснаар сурагчид багтраа өвчин тусах нь цөөрсөн
- Илүү цэвэр агаар, & хүлэмжийн хийн ялгарал буурсан.

ГЭМТ ХЭРГЭЭС СЭРГИЙЛЭХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Гудамжинд олон хүнтэй, гэрэлтүүлэг сайн, гудамжны тохижилт сайжирснаар гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх аюулгүй байдал нэмэгдсэн.
- Сурагчид хамтдаа эсвэл том хүнтэй хамт алхах эсвэл дугуй унах үед хүчирхийлэл, зөрчил багассан.

ХҮМҮҮСИЙН ХОЛБОГДСОН БАЙДАЛ

- Хамтдаа алхах, дугуй унах замаар сурагчдын нөхөрлөл, харилцаа холбоо илүү бат бөх болно.
- Гэр бүл, хөршүүдийн нийгмийн эерэг холбоо үүснэ.

ЭРҮҮЛ СУРАГЧ

- Илүү их алхах, дугуй унах замаар эрүүл мэнд сайжирч, яс булчин, үе мөч хүчтэй болно.
- Архаг өвчин, чихрийн шижин, таргалалтын эрсдэлийг бууруулна.

СУРГУУЛИЙН ТЭЭВРИЙН ШИЙДЭЛ

- Сургууль руу хүргэх аюулгүй маршрутаар дамжуулан автобусны үйлчилгээ багассан эсвэл огт байхгүй шийдлүүд
- Хичээл орох, тарах үеийн замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулсан.

ИЛҮҮ АКАДЕМИК ГҮЙЦЭТГЭЛ

- Хичээл эхлэхээс өмнө идэвхтэй сурдаг хүүхдүүдийн анхаарал төвлөрөл сайжирч, анхаарал сарнилт багасана.
- Сурагчид хамтдаа алхах, дугуй унах үед хичээл таслах нь цөөрч, хоцрогдол багатай болно.



Benefits of Safe Routes to School

Safe Routes to School improves sidewalks and street crossings and creates safe, convenient, and fun opportunities for children to bicycle and walk to and from school. The CDC has recognized Safe Routes to School as one of a handful of programs that are cost-effective and show significant population health impacts within five years. saferroutespartnership.org

COST SAVINGS

- Household savings from reduced gas & car use
- Education budget savings through reduced student housing costs

TRAFFIC SAFETY

- Reduced traffic injuries & dangers for students and community members at arrival & dismissal through street improvements near schools
- More chances to learn & practice road safety for students

CLIMATE BENEFITS AND CLEANER AIR

- Fewer student asthma attacks due to less driving & reduced air pollution results
- Cleaner air & reduced greenhouse gas emissions

SAFETY FROM CRIME

- Increased safety from crime & violence due to more people on the streets, good lighting & better street design
- Less harassment, bullying, or violence when students walk or bike together or with adults

COMMUNITY CONNECTEDNESS

- Stronger student friendships & relationships through walking & biking together
- Positive social connections for families & neighbors

HEALTHIER STUDENTS

- Better health & stronger bones, muscles & joints through more walking & biking
- Reduced risk of chronic disease, diabetes, & obesity

SCHOOL TRANSPORTATION FIXES

- Solutions to reduced or non-existent bus service through Safe Routes to School
- Reduced traffic congestion at pick-up/drop-off times

BETTER ACADEMIC PERFORMANCE

- Better focus, improved concentration & less distraction for students who are active before school
- Fewer absences and less tardiness when students walk or bike in groups




Дасгал ажил 1


Аюулгүй зам хөндлөн гарах үйл явц¹²

Доорх зургийг анхааралтай хараад тохиолдол тус бүрд Аюулгүй Зам Хөндлөн Гарах үйл явцыг бичээрэй.

Зураг А.



Зураг Б.



Зураг А

1. _____
2. _____
3. _____
4. _____


Зураг Б.

1. _____
2. _____
3. _____
4. _____
5. _____

¹² Энэхүү дасгал ажлын хуудасны зургийг Road4us-ээс авсан болно <https://road4us.org/en/>.

Дасгал ажил 2 (а)

Зам хөндлөн гарахад аюултай газрууд¹³




Энэ зурагт ямар тохиолдлыг харуулж байна?

Яагаад замын хажууд зогссон автомашины дундуур зам хөндлөн гарахад аюултай вэ?

¹³ Эдгээр график-зургийг *Move Ahead with Street Sense* Teacher Resource Booklet Stage 2. 1999. Centre for Road Safety NSW, Australia товхимолоос авсан болно.


Дасгал ажил 2 (б)
Зам хөндлөн гарахад аюултай газрууд



Авто замын муруй хэсэгт болон түүнд ойр газар зам хөндлөн гарах нь яагаад аюултай вэ?

Дасгал ажил 2 (в)


Зам хөндлөн гарахад аюултай газрууд



Яагаад өгсүүр хэсгийн оройгоор зам хөндлөн гарах аюултай газар байдаг вэ?

Дасгал ажил 2 (г)


Зам хөндлөн гарахад аюултай газрууд



Автобус ойрхон байхад зам хөндлөн гарах яагаад аюултай вэ?

Дасгал ажил 2 (д)

Зам хөндлөн гарахад аюултай газрууд



Явган зорчигч зам хөндлөн гарахдаа жолооч нарт харагдаж байх нь яагаад чухал вэ?

Жолооч нарт явган зорчигчийг харахад юу саад болдог вэ?

Дасгал ажил 2

Зам хөндлөн гарахад аюултай газрууд

Хариултын хуудас¹⁴

- (a) Зогссон автомашинуудын дундуур зам хөндлөн гарах аюултай байдгийн учир нь замын хөдөлгөөнийг сайн харж чадахгүй, мөн жолооч нар хүүхдийг харж чадахгүй.
- (b) Авто замын муруй тохойрсон хэсэгт болон түүнд ойр газар зам хөндлөн гарах нь аюултай, учир нь ирж буй хөдөлгөөнийг харахад хүндрэлтэй байдаг. Мөн түүнчлэн жолооч нар явган зорчигчдыг харахад хүндрэлтэй байдаг. Зам хөндлөн гарахдаа явган зорчигчид өөрсдөө болон ойртож буй тээврийн хэрэгслийн хооронд шулуун хараатай байх нь чухал юм.
- (c) Энэ тохиолдолд зам хөндлөн гарах нь аюултай, учир нь олон эгнээтэй зам бөгөөд энд төрөл бүрийн тээврийн хэрэгсэл явахаас гадна ачаалал ихтэй байдаг. Энд явган хүний гарц байдаггүй ба жолооч нар явган зорчигч зам хөндлөн гарна гэж төсөөлөөгүй байдаг. Олон эгнээ бүхий замын хөдөлгөөнд жолооч нар явган зорчигчийг сайн хардаггүй.
- (d) Өгсүүр замын оройн хэсэг нь аюултай газар, учир нь жолооч, явган зорчигч хоёуланд нь үзэгдэлт хязгаарлагдмал байдаг. Жолооч хэдийгээр явган зорчигчийн тодорхой зайд олж харсан ч түүнийг мөргөхгүйгээр тоормослох хугацаа хангалтгүй юм.
- (e) Автобус явган зорчигчийг замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарын хараанаас халхалж болзошгүй тул автобус ойрхон байгаа үед зам хөндлөн гарах нь аюултай. Эсрэг чиглэлд явж буй жолооч нар автобусны ард яваа явган зорчигчийг харж чадахгүй.
- (f) Явган зорчигч зам хөндлөн гарч буй нь жолоочид харагдаж байх нь хангалттай тоормослох зайг жолооч нарт олгодог бөгөөд явган зорчигчид авто замыг аюулгүй хөндлөн гарах юм. Мод, бут, барилга, хашаа, зар сурталчилгааны самбар гэх мэт явган зорчигчийг нуух/хаах нь жолооч нарт тэднийг харахад бэрхшээлтэй болгодог.

¹⁴ Дасгал ажил 2-ийн хариултын хуудсан дээрх мэдээллийг *Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2*. 1999. Centre for Road Safety NSW, Australia товхимолоос авсан болно.

Дасгал ажил 3

Аюулгүй явган зорчигч гэж хэнийг хэлэх вэ?

Зураг А.




Энэ зурагт юу харагдаж байна вэ? _____

Энэ яагаад аюултай вэ?

Дараа нь юу тохиолдож болох вэ?

Зураг Б.



Энэ зурагт юу харагдаж байна вэ?

Явган зорчигч өөрийнхөө аюулгүй байдлаа хэрхэн хангаж байна вэ?

Дасгал ажил 4

Явган зорчигчийн аюулгүй байдлын судалгаа¹⁵

Сургуулийнхаа нутаг дэвсгэрт явж байгаа том хүн болон сурагч нараас бүрдсэн найм хүртэлх хүнийг сонгон тэдний аюулгүй байдлын түвшинг ажиглаж, үнэлнэ үү.

Таны байршил: _____

Таны нэр: _____

ЯВГАН ЗОРЧИГЧ А (том хүн) С (хүүхэд)	Хүүхэд эсвэл Том хүн	Тэд зам хөндлөн гарахдаа аюулгүй газрыг сонгож байна уу?	Тэд зогсолт хийсэн үү?	Тэд хоёр тийшээ харж, сонсож байна уу?	Тэд мэдрэмжтэй алхаж байсан уу?	Таны аюулгүй байдлын өрөнхий үнэлгээ 1 (маш аюулгүй) 5 (аюултай)
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
НИЙТ						

Зам хөндлөн гарах үйл явц нь хамгийн аюулгүй байдлыг мөрдөж явсан явган зорчигч хэд байсан бэ?

¹⁵ Эдгээр дасгал ажлууд нь *Move Ahead with Street Sense* Teacher Resource Booklet Stage 2. 1999. Centre for Road Safety NSW, Australia товхимолоос авсан болно.


Хэн нь аюулгүй байсан бэ? Сурагч уу эсвэл Том хүн үү?

Таны сургуулийн ойролцоо явж буй явган зорчигчийн зан байдлыг сайжруулах 3 зүйлийг тодорхойлно уу.

1. _____
2. _____
3. _____

Дасгал ажил 5

Зам хөндлөн гарахдаа том хүний гараас хөтлөх¹⁶



1. Хоёр том хүүхэд нь хэрхэн аюулгүй байдлаа хангаж байна вэ?

2. Яагаад тэд гар гараасаа хөтөлсөн байна вэ?

3. Дараа нь юу хийж болохыг тайлбарлана уу. Аюулгүй байдлын ямар дүрмийг тэд дагаж мөрдөх ёстой вэ?

¹⁶ Зургийг "National Centre for Injury Prevention and Control Colour Me Safe www.cdc.gov/safechild" –ээс хуулбарласан болно.

Дасгал ажил 6

Зам хөндлөн гарахад аюулгүй газрууд¹⁷

1. Доорх хүснэгтэд байгаа үгийг ашиглан орхисон зайнд нөхөж бич:

Зам хөндлөн гарахад хамгийн аюулгүй газар бол гарцын тэмдэглэлтэй замын хэсэг юм. Хэрэв _____ байхгүй бол автобус, ачааны автомашины жолооч чамайг харж чадах, чи автомашинуудыг харж чадах _____ нь аюулгүй зам хөндлөн гарах замын хэсэг байх болно. Замын хөдөлгөөний _____ нөхцөл тогтмол _____ байдаг. Тиймээс аюулгүй _____ газар _____ болно. Та _____ гарцан дээр байгаа учир _____ зогсох болно гэж хэзээ ч бүү бод. Зам хөндлөн гарах бүрдээ _____, _____, _____ гэдгийг санаарай.

• БОД!	• өөрчлөгдөж	• ХАР!	• Зам хөндлөн гарах	• ЗОГС!	• орчин
• Замын тэмдэглэл	• Явган зорчигчийн	• жолооч	• Өөрчлөгдөж	• СОНС!	• газар

2. Өөрийнхөө нутаг дэвсгэрт зам хөндлөн гарах хоёр аюулгүй газрыг тодорхойлно уу:

3. Энэ газрыг юу аюултай болгож байна вэ?

4. Өөрийнхөө нутаг дэвсгэрт зам хөндлөн гарах хоёр аюултай газрыг тодорхойлно уу:

5. Би аюулгүй явган зорчигч байж чадна. Хэрэв би ...

¹⁷ Эдгээр дасгалууд нь "Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2. 1999. Centre for Road Safety NSW, Australia" товхимолоос авсан болно.

ЗОГС! Юуны төлөө? _____

ХАР! Юу? _____

СОНС! Юуг? _____

БОД! Юун тухай? _____

Дасгал ажил 7

Аюулгүй автомашинаар зорчигчид

Юу тохиолдох вэ? Хэрэв ...?¹⁸

Явган хүний зам руу автомашинаасаа гарах хэрэгтэй болоход таны цаана хоёр хүн сууж байвал яах вэ?	Хэрэв та найзынхаа автомашинд зорчиж явах үед таны суудлын бүс сандлын араар бүслэгдсэн байвал та яах вэ?
Хэрэв аав чинь автомашинаа асаагаад ээж чинь суудлын бүсээ зүүгээгүй байгааг анзаарвал яах вэ?	Хэрэв чамайг бүсээ бүсэлсэн байхад автомашины цонх онгорхой үед дүү чинь толгой эсвэл гараа цонхоор гаргавал яах вэ?
Хэрэв та хичээлээсээ хоцроод гүйж явахад замын эсрэг талд ах чинь гараараа даллан автомашин руугаа ир хэмээн дуудвал яах вэ?	Таныг очиход автомашины арын суудалд гурван том хүн байвал яах вэ?
Хэрэв таныг машинд суухад том эгч чинь, гэр чинь ойрхон юм чинь суудлын бүсээ бүслэх хэрэггүй дээ гэж хэлбэл яах вэ?	Хэрэв та автомашинаасаа буугаад зам хөндлөн гарах болбол яах вэ?
Хэрэв та хөдөөгөөр аялж явах үед дүү чинь суудлын бүсээ бүслээгүй бол яах вэ?	Хэрэв та автомашины арын суудал дээр хүнд зүйл байгааг анзаарсан бол яах вэ?
Хэрэв та автомашиндаа унтах болбол яах вэ?	Хэрэв та замын хажуугийн хаалганы дэргэд автомашин дотроо сууж байгаад буух хэрэгтэй болох үед зам дээр зогсох таны том ах танд бүү хөдөл гэж хэлбэл яах вэ?

Дөрвөн сурагч баг болж тоглоно. Хоёр сурагч ээлжлэн уг мэдэгдлийг уншаад энэ нь бодит баримт эсвэл үзэл санаа мөн эсэхийг шийдэж, шалтгааныг тайлбарлаж өгнө. Бусад хоёр сурагч сонсож, хариулт нь зөв үү эсвэл дахин хариулах ёстой юу гэдгийг шийднэ.

Сурагчид дасгалын үеэр дүрээ солилцох тул бүгд мэдэгдэл уншиж, хариулт өгч, хариулт зөв эсэхийг шийддэг.

¹⁸ Дасгал ажил нь “*Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2*. Centre for Road Safety NSW, Australia, 1999” товхимол дээр үндэслэсэн болно.

Дасгал ажил 8

Автобусаар зорчигч, Бодит байдал уу эсвэл Үзэл санаа юу тоглоом¹⁹

Автобусаас илүү суудлын автомашинаар явах нь илүү хөгжилтэй.	Автобусны зогсоол нь зарим үед хүүхдүүдэд аюултай газар болдог.
Биеийн аль ч хэсгийг автобусаас гадагш гаргах нь аюултай.	Хэн ч автобусанд суухгүйн тулд айл бүр автомашинтай байх ёстой.
Аюулгүй газраар зам хөндлөн гарахаасаа өмнө автобусыг явахыг хүлээх хэрэгтэй.	Сургуулийн цүнхээ автобусны коридорт үлдээх нь аюултай.
Хэрэв та тэнцвэр сайтай бол автобусны дээд бариулаас <u>барих эсвэл суудалд суухгүйгээр</u> зогсож явах нь аюулгүй юм.	Бага ангийн хүүхдүүд нь ганцаараа зам хөндлөн гарахад <u>хангалттай насанд</u> хүрсэн.
Хэрэв та насанд хүрсэн бол хурд саарч байхад автобусаас буухад гэмгүй.	Автобусны урдуур зам хөндлөн гарах нь хэзээд аюултай.
Бүх автобуснууд ослын гарцтай байдаг.	Автобусаас буух гэж байхдаа чихэвч зүүх нь аюултай..
Хэрэв холын зайн автобус нь хамгаалалтын бүстэй бол жолооч, зорчигчид хамгаалалтын бүс зүүвэл аюулгүй байх болно.	Бүх автобуснууд хэт их хүнтэй байдаг.

Дөрвөн сурагч баг болж тоглоно. Хоёр сурагч ээлжлэн уг мэдэгдлийг уншаад энэ нь бодит баримт эсвэл үзэл санаа мөн эсэхийг шийдэж, шалтгааныг тайлбарлаж өгнө. Бусад хоёр сурагч сонсож, хариулт нь зөв үү эсвэл дахин хариулах ёстой юу гэдгийг шийднэ.

Сурагчид дасгалын үеэр дүрээ солилцох тул бүгд мэдэгдэл уншиж, хариулт өгч, хариулт зөв эсэхийг шийддэг..

¹⁹ Энэ дасгал нь "Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2. 1999. Centre for Road Safety NSW, Australia" товхимол дээр үндэслэсэн.

Дасгал ажил 9 (а)

Автобусаар аюулгүй зорчигч байх²⁰



Автобусаар аюулгүй зорчигч байхад юу хийх вэ? Эдгээр хүүхдүүд аюулгүй зорчигчид мөн үү?

Сургуулийн цүнх хаана байна гэж чи бодож байна? Яагаад? _____

Хэрэв автобусны коридорт цүнхийг тавьсан бол юу тохиолдох вэ? _____

Автобусны цонхоор хоосон ундааны сав шидэхийг хүссэн найздаа юу гэж хэлэх вэ? _____

Хэрэв та автобусанд суусан бол хаан зогсох байснаа үзүүл? Та юунаас барих вэ? Та цүнхээ яах байсан бэ? _____

²⁰ Энэ зургийг “*Move Ahead with Street Sense* Teacher Resource Booklet Stage 2, 1999, Centre for Road Safety NSW, Australia” товхимолоос хуулбарлав.

Дасгал ажил 9 (б)

Автобусаар аюулгүй зорчигч байх – Таны шийдвэр²¹

1. Фото зураг 1-4-т юу болж байгааг тайлбарла. Энэ нь аюулгүй эсэх талаар шийдэж, хоорондоо ярилц.
2. Хэрэв энэ нь аюултай бол сурагчид аюулгүй болохын тулд юу хийх хэрэгтэй вэ?



Фото зураг 1



Фото зураг 2



Фото зураг 3



Фото зураг 4

²¹ Зургуудыг “*Watching me, watching you. Road safety matters Years 2 and 3. Government of Queensland Australia and Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2. 1999. Centre for Road Safety NSW, Australia*” эдгээр номноос авсан болно.

Дасгал ажил 9 (в)²²

Автобусаар аюулгүй зорчигч байх – Автобус явсны дараа зам хөндлөн гарах



1. Энэ зурган дээр юу болж байна гэж та бодож байна вэ?

2. Хүү өөрийн аюулгүй байдлаа хангахын тулд юу хийх ёстой вэ?



3. Эдгээр цуврал зургуудад юу болж байна вэ?

²² Зургуудыг “*Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2*. 1999. Centre for Road Safety NSW, Australia” товхимолоос хуулбарлав.

4. Хүүхдүүд өөрсдийн аюулгүй байдлаа хэрхэн хангаж байна вэ?

5. Хоосон зайг бөглөхдөө доорх нүдэнд байгаа үг бүрийг нэг удаа ашиглаарай:

Автобусаасаа буюгаад, автобусыг _____ явтал нь _____ хэрэгтэй. Дараа нь зам хөндлөн гарах аюулгүй газрыг ашиглаарай. Зам хөндлөн гарах аюулгүй газар нь гэрлэн дохиотой замын хэсэг эсвэл явган хүний _____ байна. Хэрэв эдгээр нь байхгүй бол хамгийн _____ газар нь замын хөдөлгөөн чамд сайн харагдах, мөн суудлын автомашин, мотоцикл, автобус, ачааны автомашины жолооч нар чамайг сайн харж чадах _____ хэсэг байх хэрэгтэй. Хэзээ ч автобусны _____ зам хөндлөн гарч болохгүй. Учир нь _____ чамайг харж чадахгүй. Автобус _____ явах хүртэл хэзээ ч автобусны араар зам хөндлөн гарч болохгүй. Автобус явсны дараа замын хөдөлгөөнийг чи сайн харж, жолооч нар чамайг тод сайн харж чадна. Зам хөндлөн гарах бүрдээ _____, _____, _____, _____ -оо үргэлж санаарай.

• БОД!	• хөдөлж	• ХАР!	• урдуур	• ЗОГС!	• хол
• гарц	• аюулгүй	• жолооч нар	• хүлээх	• СОНС!	• замын

Дасгал ажил 10

Өндгийг хамгаалах ²³

Шаардлагатай материалууд:

- Баг бүрд 2 түүхий өндөг
- Том хуванцар таваг
- Хайч, үдээсний машин, скоч, утас, цавуу
- Нэг удаагийн хуванцар аяга, амны цаас, цаасан хоолой, хийн бөмбөлөгтэй боолт, порлон, хуванцар соруул (өөр боломжит бүх зүйл)
- Хувинтай ус
- Ногоон зүлэгтэй бүс
- Цементэн гадаргуутай бүс

Зааварчилгаа:


1. Багш сурагчдад түүхий өндөг үзүүлээд, заасан өндрөөс (хамгийн намхан сурагчийн өргөсөн гарын өндрөөс) унагавал юу болох вэ гэж асууна.
2. Цөөн сурагчтай жижиг багууд өгөгдсөн материалаас ашиглан өндөг тус бүрд хамгаалалтын бүрхүүл зохион бүтээнэ.
3. Баг бүр ээлжлэн хамгаалалтын бүрхүүлтэй өндөг бүрийг өөр өөр гадаргуу дээр (хувинтай ус руу, өвс эсвэл цементэн дээр) унагаана. Өндөг тус бүр ижил өндрөөс унасан эсэхийг тэд шалгана.
4. Сурагчид доорх хүснэгтийг бөглөж, өндөг унах бүрд хамгаалалтын бүрхүүл болон өндгөнд юу тохиолдсоныг тэмдэглэнэ.
5. Сурагчид үр дүнгийн талаар ярилцаж, бүрхүүлийг зохих ёсоор нь тохироогүй, бэхлээгүй тохиолдолд өндгөнд нь юу тохиолдох талаар ярилцана. Өндөгний бүрхүүл хэрхэн хамгаалалтын малгайтай адил байна вэ?
6. Сурагчид хамгаалалтын хэрэгсэл хэрхэн ажилладаг, яагаад эмзэг эрхтэн болох толгойгоо хамгаалахын тулд найдвартай бэхэлсэн дуулга, хамгаалалтын малгай өмсөх хэрэгтэй талаар тайлбарлана.

Гадаргуу	Өндөгний бүрхүүл		Өндөг	
Ус				
Өвс				
Цемент				

²³ Энэ дасгал ажлыг “Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2. 1999. Centre for Road Safety NSW, Australia” товхимолоос ишлэв.

Дасгал ажил 11

Мотоциклын хамгаалах малгай нь хэрхэн биднийг аюулгүй байлгадаг вэ²⁴



Дугуй бүрийг хайчилж, зураг дээрх зөв газарт наа.

²⁴ Зургийг “roads4us”-аас хуулбарлав. <https://road4us.org/>

Дасгал ажил 12

Сургууль руу аюулгүй зорчих – Багш удирдсан ангийн дасгал ажил



Сурагчдадаа зориулж аюулгүй маршрутыг тэмдэглэсэн сургуулийн газрын зураг хий

- Дээрх жишээ шиг сургууль болон ойролцоох гудамж замыг харуулсан газрын зураг бүтээ.
- Таних тэмдгүүдийг тодорхойлоход сурагчдадаа туслах
 - Аюулгүй тоноглолууд (жишээ нь: явган хүний зам, явган хүний гарц, гудамжны гэрэл, Цагдаа-Эцэг эхийн зогсдог гарцын байрлал)
 - Аюултай бүс (жишээ нь: явган хүний замгүй, гарцгүй, замын эргэлт, замын өгсүүр хэсгийн орой, бусад саад, олон эгнээтэй зам)
- Багш газрын зураг ашиглан хаана амьдардаг, сургууль руу алхах маршрутаа тодорхойлоход сурагчдад тусалдаг. Багш хамгийн аюулгүй зам мөн эсэхийг шалгаж, сурагчдыг чиглүүлдэг.
- Багш, сурагчид аюулгүй маршрутыг боловсруулж, сурагчид сургууль руугаа хамгийн аюулгүй замаар явах маршрутын талаар эцэг эхтэйгээ ярилцахын тулд гэр рүүгээ авч явдаг.

Дасгал ажил 13

Галт тэрэгний эргэн тойрон дахь аюулгүй байдал

Асуудал шийдвэрлэх хувилбарууд

Хувилбар 1

[Нийтлэг хүүгийн нэр] есөн настай бөгөөд тэрээр амралтаараа орон нутагт амьдардаг хамаатан садандаа зочилдог. Эцэг эх нь түүнийг галт тэрэгний ойролцоо тоглож болохгүй гэж анхааруулсан боловч орон нутагт амьдардаг үеэлүүд бүгд төмөр замын хажууд унадаг дугуйгаар явж байв. Энэ нь аюултай гэдгийг мэддэг ч тэд түүнийг нялх хүүхэд гэж бодож, түүн рүү инээлдэх вий гэж санаа зовдог. Түүний үеэлүүд галт тэрэг хэзээ ирэхийг мэддэг, эцэг эх нь хэзээ ч мэдэхгүй гэж хэлдэг. Тэр юу хийх ёстой вэ?

Хувилбар 2

[X ба Y - нийтлэг хүүгийн хоёр нэр] есөн настай бөгөөд тэд гэр лүүгээ алхаж байна. Тэд оройтож, харанхуй болж байв. Тэд төмөр замын гарам дээр явж байхад дохио дөнгөж дуугарч эхэлсэн бөгөөд одоогоор галт тэрэг алга байлаа. X гүйж очоод Y-г өөртэй нь нэгдэхийг уриалж байна. Тэрбээр цаг хугацаа хангалттай гэж хэлээд хэрвээ тэр төмөр замыг хөндлөн гарч гүйхгүй бол өөрийг нь хулчгар гэж хэлдэг. Y юу хийх ёстой вэ?

Хувилбар 3

[Нийтлэг хөвгүүний нэр ба нийтлэг охидын нэр] найм, есөн настай бөгөөд гарцын ойролцоо байдаг гэртээ харихын тулд гармаар гарах ёстой. Тэд шинэ Хөл бөмбөгийн бөмбөг тэврэн алхаж яваад бөмбөгөө алдахад төмөр зам дээгүүр доош өнхрөв. Тэд бөмбөгөө алдахыг хүсэхгүй байна. Тэд юу хийх ёстой вэ?


Хувилбар 4

Та 12 настай бөгөөд төмөр зам гатлан гэртээ харихдаа дүүгээ аюулгүй байлгах үүрэгтэй. Дүү чинь чиний гараас хөтлөхөө болиод өөрөө төмөр зам хөндлөн гараад гэртээ хурдан очихыг хүсэж байна. Чи юу хийх вэ?

Жижиг бүлгээр хувилбар бүрийг уншиж, хувилбар бүрд аюулгүй байхын тулд нэг буюу хэд хэдэн хувилбар гаргаж түүнийгээ хэлэлц. Эдгээрийг ангийнхантайгаа хуваалцаарай.

Дасгал ажил 14

Жолооч нарт харагдахуйц байх



1. Өдөр харагдахын тулд хантаазыг гэрэл цацруулагч өнгөөр буд.
2. Шөнө жолооч нарт харагдахад тусалдаг цацруулагч материалыг тодотго
3. Гэгээлэг, цацруулагчтай хувцас өмсөх нь таныг аюулгүй байлгахад хэрхэн тусалдаг талаар тайлбарлана уу.

Аюулгүйн хантааз өмссөнөөр та үргэлж аюулгүй байна гэсэн үг биш гэдгийг санаарай. Замын хөдөлгөөний дүрмийг дага, зам хөндлөн гарах болгондоо ЗОГС! ХАР! СОНС! БОД!

Дасгал ажил 15

Багш удирдсан ХАРАГДАХУЙЦ БАЙХ туршилт

Шаардлагатай материалууд:


- Гэрэл орохооргүй битүүмжлэгдсэн дунд хэмжээтэй цаасан хайрцаг
- Жижиг гар чийдэн
- Өндөр чанартай цацруулагч тууз (3М) бүхий флюоресцент материалын хэсэг эсвэл цацруулагч туузтай аюулгүйн хантааз.

Зааварчилгаа:

- Багш эвхсэн тууз/материалыг хайрцгийн дотор нэг талд нааж тогтооно. **Цацруулагч тууз харагдаж байгааг шалгаарай.**
- Багш хайрцгийг гэрэл орохооргүй бүрэн хаана.
- Хайрцгийн тууз байрласан талын эсрэг талд жижиг нүх(хүүхдийн нүдэнд тохирсон хэмжээний том байхад болно) гаргана.
- Цацруулагч тууз руу тусгах гар чийдэнд зориулж хоёр дах нүхийг хийнэ.
- Сурагчид ээлжлэн нүхээр харна. Тэд юу харж чадах вэ?
- Дараа нь багш эсвэл сурагч хайрцгийн нүхээр гэрлийг тусгана. Одоо тэд юу харж байна вэ? Яагаад ийм өөр байна вэ?
- Бүх сурагчид туршилт хийж дууссаны дараа багш флюоресцент ба цацруулагч материалын шинж чанарын талаар хэлэлцүүлгийг удирдаж явуулна. Сурагчид өвлийн улиралд өдөр бүр сургуульдаа ирж буцахдаа аюулгүйн хантааз өмсөх нь яагаад чухал болох гурван шалтгааныг бичнэ.

Дасгал ажил 16

Шөнө харагдахуйц байх²⁵






Шөнө харанхуй үед аюулгүй, тод харагдаж байсан бүх хувцас болон тоноглолоо жагсааж бич.

Энэ нь хэрхэн яаж таныг хамгаалдаг талаар тайлбарла.

²⁵ Зургийг “roads4us”-аас хуулбарлав. <https://road4us.org/>

Дасгал ажил 17 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдгүүд²⁶

	<p>Энэ тэмдэг нь жолооч нар зам дээр эсвэл замын хажууд явж байгаа хүүхдүүдийг харж, анхаарал хандуулахыг анхааруулдаг.</p>		<p>Энэ тэмдгийн утга нь жолооч бүх хөдөлгөөнд зам тавьж өгөх, эсвэл зогсолт хийх ёстойг заадаг. Энэ нь жолооч нарт зориулсан хамгийн чухал аюулгүй байдлын тэмдэг юм.</p>
	<p>Энэхүү тэмдэг нь жолооч, явган зорчигчдод төмөр зам байгааг анхааруулдаг. Явган зорчигч нар гармаар гарвал гэрэл анивчиж дуусахыг ХҮЛЭЭХ ёстой. Тэд үргэлж ЗОГСОЖ, ХАРЖ, СОНСОЖ, БОДСОНЫ дараа төмөр замыг хурдан алхаж гатлах ёстой.</p>		<p>Энэ тэмдгийн утга нь Та энэ бүсэд явж болохгүй гэдгийг заадаг. Явган зорчигчийн хөдөлгөөн хориотой тэмдэг</p>
	<p>Энэ тэмдэг нь та зам хөндлөн гарч болохгүй гэсэн үг юм. Хэрэв та аль хэдийн зам гараад явж байгаа бол зам хөндлөн гарч дуустлаа замын хөдөлгөөнийг шалгаж байгаарай.</p>		<p>Энэхүү тэмдэг нь бүх явган зорчигчдод зам хөндлөн гарах аюулгүй газар ойрхон байгааг хэлж өгдөг. Гэхдээ үргэлж аюулгүй байхын тулд ЗОГСОЖ, ХАРЖ, СОНСОЖ, БОДОЖ байх ёстой.</p>
	<p>Энэхүү гэрлэн дохио нь жолооч нарт хэзээ зогсох, хурд хасах эсвэл явахыг хэлж өгдөг. Улаан гэрэл асаж байх үед жолооч нар зогсох ёстой.</p>		<p>Энэ бол явган хүний гарцаар гарах дохионы товчлуур юм. Зам хөндлөн гарч эхлэхийн өмнө явган зорчигчид товчлуурыг нэг удаа дарж, ногоон хүн эсвэл АЛХ гэсэн тэмдэг асахыг хүлээнэ.</p>
	<p>Энэ тэмдэг жолооч нарт явган хүний гарц урд байгааг мэдээллэнэ.</p>		<p>Энэ гэрэл дохио нь таныг зам хөндлөн гарахдаа болгоомжтой гарч болохыг хэлж өгдөг. Та зам хөндлөн гарахаасаа өмнө мөн л ХАРЖ, СОНСОЖ, БОДОХ ёстой..</p>

Багш зургийг томруулж хувилах хэрэгтэй. Сурагчид тэмдэг текстийг дөрвөлжилж хайчлан карт болгоод хооронд нь холино. Зурагтай зөв тайлбарыг тааруулах замаар хоорондоо ярилцана.





²⁶ Энэ дасгал ажил нь “Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2. 1999. Centre for Road Safety NSW, Australia” товхимол дээр үндэслэгдсэн.

Дасгал ажил 18 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдгүүдийн тойм²⁷

Өгүүлбэрийг гүйцээхийн тулд доорх нүдэнд байгаа үгсийг ашиглаарай. Өгүүлбэрийг дуусгасны дараа тэмдгүүдийг өнгөөр будаж тэмдэглээрэй.

Явган зорчигч	БОД	Төмөр замын гарам	СОНС	Ногоон гэрэл	Явган зорчигчид	зогсоож
ЗОГС	хүүхдүүд	ХАР	дохио	жолооч	улаан	
						
	<p>Энэхүү тэмдэг нь замд ойрхон _____ явж байгаа тул анхаарал болгоомжтой явахыг _____ нарт анхааруулж байна.</p> <p>Гэхдээ зарим жолооч тэмдгийг тэр бүр дагаж мөрддөггүй тул өөрсдийгөө аюулгүй байлгах үүднээс явган хүний замаар эсвэл замын хөдөлгөөнөөс хол байх ёстой..</p> <p>Бид зам хөндлөн гарах бүрдээ ЗОГС! ХАР! СОНС! БОД!</p>					
	<p>Жолооч нар энэ тэмдгийг хараад тэд хөдөлгөөнөө _____, бусад хөдөлгөөнд оролцогчдод зам тавьж өгнө.</p>					
	<p>Гэрлэн дохио бол жолооч нарт замын хөдөлгөөнд оролцоход чухал _____ юм. Жолооч нар _____ гэрлээр зогсох ёстой.</p>					

²⁷ Энэ дасгал ажил нь "Move Ahead with Street Sense Teacher Resource Booklet Stage 2. 1999. Centre for Road Safety NSW, Australia" товхимол дээр үндэслэгдсэн.

	<p>Энэ тэмдгүүд _____ явахад аюулгүй газар биш гэдгийг хэлж өгдөг. Энэ тэмдэг байгаа тохиолдолд явган явах нь хууль зөрчсөн үйлдэл юм.</p>
	<p>Зарим гэрлэн дохио замын хөдөлгөөнийг зогсоохын тулд _____ зориулсан товчлууртай байдаг. Бид зам хөндлөн гарахын өмнө _____ астал замын хажууд хүлээх ёстой.</p>
	<p>Энэ тэмдэг нь бидэнд _____ урд байгааг хэлдэг. Бид өөрсдийгөө аюулгүй байлгахын тулд бүх тэмдэг, дохиог дуулгавартай дагаж, төмөр замыг гатлах бүрдээ ЗОГСож! ХАРж! СОНСож! БОДож! байх ёстой</p>
	<p>Энэ тэмдэг нь насанд хүрэгчид, хүүхдүүдэд зам хөндлөн гарах аюулгүй газар болохыг хэлж өгдөг. Гэхдээ бид зам хөндлөн гарах бүрд үргэлж _____ байх ёстой.</p>

Дасгал ажил 19

Аюулгүй дугуйчид



Дугуй унаж байгаа хүүхдүүд. Эх сурвалж: unicef.org/eap/stories/through-my-eyes-ulaanbaatar-mongolia

1. Эдгээр хөвгүүд дугуй унахдаа өөрсдийгөө хэрхэн аюулгүй байлгаж байна вэ?

2. Дугуй нь эдгээр хөвгүүдийн унах хэмжээнд тохирсон болохыг бид хэрхэн мэдэх вэ?

3. Аюулгүй дугуйчин хүүхдийг хэрхэн таньж мэдэх вэ?

1. Аюулгүй дугуйчин нь засмал замаар явахдаа сайтар түгжсэн хамгаалах малгай өмсдөг.

2. Аюулгүй дугуйчин нь _____.

3. Аюулгүй дугуйчин нь _____.


4. Аюулгүй дугуйчин нь _____.



5. Дугуйн зам дээр аль дугуйчныг харахад илүү хялбар байна вэ? Үүний шалтгааныг бүгдийг нь жагсааж бич.

Дасгал ажил 20

Унадаг дугуйн хамгаалах малгай нь бидний Тархи, Толгойг аюулгүй хамгаалдаг



Хамгаалах малгайг зөв өмссөн бол духан дээр тэгшхэн байх бөгөөд таны духыг хамгаална.

Эрүүний оосрыг зөв чанга бэхэлсэн байх. Толгойгоо арагш, урагш хөдөлгөхөд малгай хөдлөх ёсгүй.

Дугуйнаас унах, юм цохих үед малгай нь толгой болон тархийг хамгаалах бүрхүүлтэй.

Малгайн оосрыг малгай урагш хойш хөдлөхгүй байхаар тохируулна.

Малгайн агааржуулалтын цоорхойнууд нь таны толгойг сэрүүн байлгана.

Унадаг дугуйн малгай нь чих таглахгүй хийцтэй байдаг. Дугуйчин замын хөдөлгөөний дүү чимээг сонсох шаардлагатай.

Дугуй бүрийг хайчилж, малгай дээр сумаар заасан хэсэгт тохирохоор нь наа.

ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Эцэг эхчүүдэд зориулсан явган зорчигч хүүхдийн аюулгүй байдлын мэдээлэл

Монгол улсад хаа сайгүй авто замын хөдөлгөөний ачаалал ихсэж, хурд нэмэгдэж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд зам тээврийн ослоор ойролцоогоор 10000 хүүхэд нас барах эсвэл гэмтэл авсан байна.

Та өөрийн хүүхдээ мэддэг, мөн таны хүүхэд зам хөндлөн гарахдаа, замын хажуугаар алхаж явахдаа анхааралтай явахаа мартдаг гэдгийг ч та мэднэ. Таны хүүхдийн хурдыг үнэлэх, аюулыг урьдчилан таамаглах, тодорхойлох, дуу чимээ аль чиглэлээс гарч байгааг мэдэх талаарх мэдлэг, ур чадвар хөгжсөөр байна.

Та хүүхдээ 10 нас хүртэл нь замын хөдөлгөөнд оролцох үед нь маш сайн хяналт тавиарай. Зам хөндлөн гарах бүрд тэдний гараас хөтлөөрэй. Хэрэв та хүүхэдтэйгээ хамт байж чадахгүй бол итгэмжлэгдсэн насанд хүрэгчдийг (12-аас дээш насны төлөвшсөн, мэдрэмжтэй хүн) тэднийг дагалдуулах ажлыг зохион байгуулаарай.


Хамтдаа алхах болгондоо сургууль дээр нь зааж өгч буй явган хүний аюулгүй байдлын мэдээллийг сурахад нь тусална уу. Хамтдаа алхаж байхдаа дараах сэдвээр хүүхэдтэйгээ ярилцаарай:

- Аюулгүй байх үүднээс үргэлж явган хүний замаар алхах.
- Авто зогсоолоос эсвэл зорчих хэсгээс гарч буй тээврийн хэрэгслийн аюулын талаар.
- Гэрлэн дохио болон явган хүний гарцыг зөв ашиглах. Зам хөндлөн гарахаасаа өмнө бүх автомашинуудыг зогсох хүртэл хүлээх. Зарим жолооч явган зорчигчдод зогсож өгөхгүй байж болзошгүйг хүүхэд тань мэдэж байгаа эсэхийг шалгаарай.
- Явган хүний гарцгүй замд зам хөндлөн гарах аюулгүй газар сонгох.
 - Зогсож буй автомашинуудын дундуур явж зам хөндлөн гарч болохгүй, учир нь жолооч чамайг харж чадахгүй.
 - Жолоочийн үзэгдэлт халхлагдсан замын хэсэг болох булан эсвэл тохойрсон хэсэг, өөр бусад газраар хэзээ ч зам хөндлөн гарч болохгүй
 - Зам хөндлөн гарахдаа үргэлж замын хөдөлгөөнийг харж, бодох хэрэгтэй
- Зам хөндлөн гарч байхдаа хэзээ ч гар утас ашиглаж, мессеж бичиж болохгүй.

Сургуульдаа сурсан мэдээллийг бататгах:

- 10 нас хүртлээ зам хөндлөн гарахдаа насанд хүрсэн хүний гараас хөтлөх.
- Замын аюулгүй хэсгийг сонгож зам хөндлөн гарах.
- Зам хөндлөн гарах бүрдээ:
 - **ЗОГС!** Замын ирмэг эсвэл хашлагаас нэг алхам ухарч зогс.
 - **ХАР!** Сайн тод харахын тулд замын хоёр чиг рүү толгойгоо эргүүлж харах.
 - **СОНС!** Ирж буй хөдөлгөөний чимээг сонсох.
 - **БОД!** Зам хөндлөн гарах нь аюулгүй эсэх.
- Автобуснаас буугаад зам хөндлөн гарах бүрдээ:
 - Автобус явахыг **ХҮЛЭЭХ**, замын аюулгүй хэсгийг сонгож зам хөндлөн гарах.
 - Том хүний гараас **ХӨТЛӨХ** эсвэл автобуснаас буусан насанд хүрсэн хүнтэй цуг алхах.
 - **ЗОГС! ХАР! СОНС! БОД!**
 - Зам хөндлөн гарахдаа замын хөдөлгөөнийг нягтлангаа эгц шулуун **АЛХАХ**.


Аюулгүй явган зорчигч байх тухай хүүхэдтэйгээ ярилцахдаа эдгээр зургийг ашиглаарай.




**ЗОГСОЖ БУЙ АВТОМАШИНУУДЫН ДУНДУУР ЯВЖ ЗАМ ХӨНДЛӨН ГАРЧ БОЛОХГҮЙ.
ЖОЛООЧ ЧАМАЙГ ХАРЖ ЧАДАХГҮЙ.**



ЖОЛООЧ ЧАМАЙГ ХАРЖ ЧАДАХ АЮУЛГҮЙ ГАЗРЫГ СОНГО



ЗАМ ХӨНДЛӨН ГАРАХ БҮРДЭЭ ЦАГ ҮРГЭЛЖ ЗОГС! ХАР! СОНС! БОД!



НАСАНД ХҮРЭГЧИД ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ТАЛД АЛХАХ ЁСТОЙ

Эцэг эхчүүдэд зориулсан аюулгүй зорчигч хүүхдийн тухай мэдээлэл

Сургууль дээрээ таны хүүхэд суудлын автомашинаар хэрхэн аюулгүй зорчих талаар судалсан болно. Автомашинаар зорчиж явахдаа хүүхэддээ зорчигчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгээ ойлгож сурахад нь тусална уу.

Та хүүхдийнхээ аюулгүй байдалд хариуцлага хүлээнэ. Та бол хүүхдийнхээ хамгийн чухал үлгэр жишээ загвар юм. Хүүхдүүд эцэг эхийнхээ хийж байгааг үйлийг харж байдаг бөгөөд харсан зүйлээ хийдэг тул аялал богино байхаас үл харгалзан та суудлын бүсээ үргэлж бүсэлж байгаарай.

Хүн бүр суудлын бүсээ зөв бүслэхгүй бол автомашин хөдлөхгүй гэсэн гэр бүлийн дүрэмтэй болоорой.

Хүүхдүүдээ сурахад нь туслахын тулд тасралтгүй бататгаж бэхжүүлэх хэрэгтэй. Суудлын бүсээ мөр, ташаан дээгүүрээ зөв зүүж байх хэрэгтэй гэдгийг тэдэнд цаг үргэлж сануулж байх хэрэгтэй. Шаардлагатай бол бүсээ бүсэлсэн эсэхийг шалгана уу.

Автомашинаар зорчиж байхдаа хүүхэдтэйгээ дараах зүйлийн талаар ярилцаарай:

Тэд яагаад 12 нас хүртлээ арын суудалд суух ёстой вэ, яагаад гэвэл энэ нь тэдний жижигхэн эмзэг биеийг урд суудалтай харьцуулахад илүү өндөр түвшинд хамгаалдаг.

Яагаад тэд хэзээ ч зогсож явж болохгүй вэ, учир нь гэнэт зогсох эсвэл мөргөлдөх үед унах, гар, хөлөө хугалах эрсдэл тэдэнд маш өндөр байдаг.

Яагаад тэд биеийнхээ аль ч хэсгийг тээврийн хэрэгслээс гадагш хэзээ ч гаргаж болохгүй вэ.


Хэрэв суудлын автомашинд хангалттай бүс байхгүй бол хэн нэгэн нь гэртээ үлдэх хэрэгтэй.

Сургуульдаа сурсан мэдлэгийг нь бататгах:

Аялал бүрдээ үргэлж суудлын бүсээ бүслэх.

12 нас хүртлээ арын суудалд суух.

Автомашины "аюулгүй хаалга"-наас үргэлж бууж, суух - замын хашлага талын арын хаалга.



Автомашинаар зорчихдоо бүх зорчигчид суудлын бүсээ бүсэлсэн байдал. Эх сурвалж:

<https://road4us.org/en/>

Эцэг эхчүүдэд зориулсан галт тэрэгний аюулгүй байдлын тухай мэдээлэл

Таны хүүхэд сургуульдаа галт тэрэг, төмөр зам, төмөр замын гармын ойролцоо хэрхэн аюулгүй байдлаа хадгалах талаар сурч байна. Тэд хаана амьдардаг, галт тэрэг, төмөр замыг хэр олон удаа харж байснаас үл хамааран аюулгүй байдлаа хангахын тулд тогтмол бэлтгэл хийж байх хэрэгтэй.

Бага насны хүүхдүүдэд галт тэрэг, төмөр замын ойролцоо аюулгүй байдлаа хадгалахад нь туслахын тулд тасралтгүй бататгах хэрэгтэй. Хүүхдэдээ галт тэрэг ба төмөр замын аюулгүй байдлын тухай ангидаа сурсан мэдлэг, мэдээллийг нь галт тэрэгний буудлын тавцан дээр зогсож байхдаа эсвэл төмөр зам хөндлөн гарах үедээ давтаж, бататгахад нь тусална уу.

Хүүхдүүд галт тэрэг ямар аюультайг бүрэн сайн ойлгодоггүй, ялангуяа анхаарал сарнисан эсвэл эрсдэлтэй алхам хийхэд хүргэсэн тохиолдол бүрд тэд үргэлж аюулгүй алхам хийж чаддаггүй.

Галт тэрэгний буудлын тавцан дээрх аюулгүй байдал:

- Галт тэрэгний буудлын тавцан дээр хүүхдийг 10 нас хүртэл нь үргэлж идэвхтэй удирдаж, гараас нь хөтөлж, эсвэл тэднийг өөр аюулгүй зүйлээс, жишээ нь таны хувцаснаас, ах эгчийн гараас эсвэл тэрэгний бариулаас бариулах хэрэгтэй.
- Аюулгүй байдлын шар шугамын тухай, яагаад хүүхэд, насанд хүрэгчид бүгд шугамын ард зогсох ёстой талаар ярилц. Галт тэрэг ирэхэд шар шугамыг давж гарахаасаа өмнө галт тэргийг бүрэн зогсох хүртэл нь хүлээнэ.
- Төрөл бүрийн аюулгүй байдлын онцлогуудын талаар, жишээ нь, шар шугам, тэмдгийн тухай ярилц; яагаад эдгээр аюулгүй байдлын хэрэгслүүд тэнд байдаг вэ; тэд хэрхэн бидний аюулгүй байдлыг хангадаг вэ.


Төмөр замын аюулгүй байдал

- Төмөр замын гарам эсвэл төмөр зам руу ойртон ирэхдээ хүүхдийнхээ гараас хөтлөөрэй. Хэрэв та хүүхдийнхээ гараас хөтөлж чадахгүй бол хувцасныхаа нэг хэсэг, цүнх, ах эгчийнх нь гар гэх мэт аюулгүй хувилбараас бариулна.
- Төмөр замын гарам эсвэл төмөр замаас холхон зогсож, хүүхэдтэйгээ юу харж байгаа талаар нь ярилцаарай. Аюулгүй байдлын хэрэгслүүдийг зааж өгөөрэй. (жишээ нь, тэмдэг, дуут дохио, бусад аюулгүй байдлын тоноглол). Бид төмөр замын тэмдгийг хэрхэн дагаж мөрддөг талаар ярилцаарай.
- Галт тэрэг ямар ч үед ирж болзошгүй байдаг талаар дахин хэлж өгөөрэй.
- Зам хөндлөн гарахдаа үргэлж тохиромжтой газар байгаа эсэхийг нягтлаад түүнийг ашиглаж байх хэрэгтэйг тэдэнд сануулж хэлээрэй. Жишээ нь, хоёр тийшээ сайн харагдах газар эсвэл явган зорчигчийн гарам.
- **ГАРМААР ГАРАХ ҮЙЛ ЯВЦЫН** талаар ярилцаарай.
 1. **ХҮЛЭЭ!** Дуут дохио болон анивчих гэрэл унтрах хүртэл, мөн явган хүний хаалтыг нээгдтэл хүлээ.
 2. **ЗОГС!** Гарам дээрх зогс шугамын ард зогс.

3. ХАРИ Хоёр тийш галт тэрэг байгаа эсэхийг хар. Сайн харахын тулд толгойгоо эргүүлж хар.
 4. СОНСИ Галт тэрэг ирж байгаа эсэхийг сонс Чихэвчээ ав.
 5. БОД, “Зам хөндлөн гарахад аюулгүй юу?”
- Хүүхдүүдийг төмөр замын ойролцоо байх бүрдээ чихэвчээ тайлж, хөдөлгөөнт төхөөрөмж харахаа болих хэрэгтэй гэдгийг сануулаарай..
 - Хэрэв галт тэрэг дамжин өнгөрвөл, галт тэрэг хэр том хэмжээтэй, жолооч түүний зогсооход хэчнээн хэцүү болохыг ярьж өгөөрэй. Галт тэрэг автомашин шиг хурдан зогсож чадахгүй ба чамаас зайлсхийхийн тулд төмөр замаасаа гарч чадахгүй гэдгийг тэдэнд сануулаарай.
 - Унадаг дугуй төмөр зам дээр гацаж болзошгүйг тэдэнд сануул. Тэд дугуйнаасаа буугаад төмөр зам дээгүүр алхах ёстой. Хэрэв зам дээр ямар нэгэн зүйл гацсан эсвэл зам дээр бөмбөг өнхөрч байвал түүнийг орхиж, том хүнээс тусламж хүсэх хэрэгтэй.

Зам хөндлөн гарах болгондоо үүнийг хийх нь яагаад чухал вэ?

Энэ нь таны хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангахад тусална!



Эх үүсвэр: [Pixel perfect](https://www.flaticon.com) компанийн хийсэн тэмдэг www.flaticon.com

**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын статистик,
2009-2019 он**

	Он	Нийт	Орон нутаг	Улаанбаата р
	Нас барсан	2009	36	27
2010		28	18	10
2011		40	26	14
2013		37	27	10
2014		48	38	10
2015		54	42	12
2016		50	45	5
2017		55	46	9
2018		45	12	33
2019		49	38	11
2009-2019		442	319	123
Гэмтсэн		2009	538	54
	2010	656	45	611
	2011	935	59	876
	2013	1,231	81	1,150
	2014	1,164	95	1,069
	2015	1,089	91	998
	2016	1,065	95	970
	2017	1,058	138	920
	2018	1,001	131	870
	2019	770	165	605
	2009-2019	9,507	954	8,553
Нийт нас барсан болон гэмтсэн хүн	2009-2019	9,949	1,273	8,676

**Монгол улсад 2009 он ба 2019 онд бүртгэгдсэн
тээврийн хэрэгслүүд**

Он	Суудлын автомашин	Ачааны автомашин	Автобус	Мотоцикл
2009	153,917	47,337	16,920	31,730
2019	667,375	203,675	19,535	46,951

Он	Цистерн	Хагас чиргүүлтэй ачааны автомашин	Чиргүүл	Механизм	Тусгай	Нийт
2009	482	---	6,085	3,706	6253	266,430
2019	6,493	23,850	47,972	13,595	13,582	1,043,028

Эх сурвалж: Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл, 2020 он

Ашигласан материал ба нэмэлт мэдээлэл

1. Association Prévention Routière and the Group Renault Foundation, 2020. *Road4us*. <https://road4us.org/>
2. National Centre for Injury Prevention and Control. *Colour Me Safe* www.cdc.gov/safecchild
3. European Transport Safety Council (ETSC), 2020 LEARN Project *Key Principles for Traffic Safety and Mobility Education*. <https://etsc.eu>
4. Government of Mongolia, National Statistical Office. *Traffic accident statistic book, 2020*.
5. Government of Queensland, Australia. *Watching me watching you. Road safety matters for Years 2 and 3*.
6. International Road Assessment Program, 2020. *Star Rating for Schools*. www.starratingforschools.org/
7. KROS (Knights for Road Safety) Erasmus+ programme (KA2 - Cooperation for Innovation and the Exchange of Good Practices: Strategic Partnerships for school education), 2020. <http://www.kros-project.eu>
8. TrackSAFE Foundation 2020. *TrackSAFE Education, Rail Safety for Schools* Canberra, Australia. Email: info@tracksafefoundation.com.au
9. NSW Centre for Road Safety, 1999 *Move Ahead with Street Sense Stage Two*. New South Wales, Australia roadsafety.transport.nsw.gov.au
10. Transport Research Laboratory, 1997 *Road safety education in developing countries. Overseas road note 17*. Berkshire, UK. <https://trl.co.uk/about-us/transport-research-foundation>
11. World Bank (2019). *Guide for Road Safety Opportunities and Challenges: Low- and Middle-Income Countries Country Profiles*. Washington, DC., USA World Bank.

Нэмэлт эх сурвалж

1. Association Prévention Routière and the Group Renault Foundation, 2020. *Road4us*. <https://road4us.org/>
2. Eastern Alliance for Safe and Sustainable Transport (EASST) *Road Safety Education Pack* www.easst.co.uk. The Pack for children 6-11 years has been translated into Mongolian. (see below)
3. EASST Academy *Road Safety Education Pack* – A free course for teachers, educators, parents, carers, and NGOs. EASST provides a Course Completion Certificate <https://easstacademy.org/how-use-easst-road-safety-education-pack>
4. International Road Assessment Program, 2020. *Star Rating for Schools*. www.starratingforschools.org/

5. National Centre for Injury Prevention and Control. Colour Me Safe
www.cdc.gov/safechild
6. NSW Centre for Road Safety 'Safety Town'. This website contains interactive road safety videos and student-centred activities suitable for students aged from 8 years old which they can access for free.
<https://www.safetytown.com.au/town/student/stage-2/#list>
7. Safety4kids <https://www.safety4kids.com.au/resources>

